



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГААС ОРОН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА ТӨСӨЛ,
ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТ, ҮР НӨЛӨӨ”

*“Гадаадын хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны чиглэлээр орон нутагт
хэрэгжүүлэх бодлого, чиглэл боловсруулж, тус үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар
хангах шаардлагатай байна.”*

АУДИТЫН КОД: ДУА-2021/81-ШТА-ГА

Аудитын менежер Х.Наранцацрал
Утас: 70592225 Цахим хаяг: narantsatsralkh@audit.gov.mn
Ахлах аудитор Д.Ихбаяр
Утас: 70592208 Цахим хаяг: ikhbayard@audit.gov.mn
Аудитор Д.Должинсүрэн
Утас: 70592208 Цахим хаяг: doljinsurend@audit.gov.mn

Мандалговь хот 2021 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгс	3
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4-5
	Үндсэн мэдээлэл	6-7
	Дүрслэлийн товч	8
Аудитын менежер Х.Наранцацрал	<u>Бүлэг А. Гадаадын зээл түслэмжээр ТАХ хэрэгжүүлэх талаар орон нутагт баримтлах нэгдсэн хөтөлбөр байхгүй, төлөвлөлт хангалтгүй байна.</u>	9-13
Ахлах аудитор Д.Ихбаяр	А.1 Дундговь аймаг гадаад харилцаанд баримтлах нэгдсэн хөтөлбөр, зохион байгуулалт байхгүйгээс Засгийн газрын болон бусад шугамаар хэрэгжиж буй ТАХ-г орон нутагт хэрэгжүүлэх боломжийг алдсан байна.	9-10
Аудитор Д.Должинсүрэн	А.2 Гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр хийх ажлыг аймгийн урт болон дунд хугацаанд хэрэгжүүлэх бодлоготой уялдуулан, нарийвчлан төлөвлөж, хэрэгжүүлэх ажил хангалтгүй байсан байна.	10-13
	<u>Бүлэг Б. ТАХ гэрээ хэлэлцээрийн дагуу үр дүнтэй хэрэгжүүлсэн боловч, төслийн хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг тооцож ажиллаагүй байна.</u>	14-21
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70592208 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.	Б.1. Төслийн батлагдсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.	14-18
	Б.2 Төслийн хэрэгжилтэд төсвийн ерөнхийлөн захирагчаас хяналт тавих ажил хийгдээгүй байна.	18-21
	Дүгнэлт	22
	Зөвлөмж	23
ХАЯГ:	Шалгагдагч байгууллагын санал	24
Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 219 тоот	Тайлан баталгаажуулсан тушаал	25-28
	Хавсралт	30-34
2021 оны 7 дугаар сар		

ТОВЧИЛСОН ҮГС

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТАХ	Төсөл, арга хэмжээ
БНХАУ	Бүгд найрамдах хятад ард улс
ОУ	Олон улс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХАА	Худалдан авах ажиллагаа
БНСУ	Бүгд найрамдах солонгос улс
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТББ	Төрийн бус байгууллага
БИНХ	Багийн иргэдийн нийтийн хурал
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгч
УИХ	Улсын их хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЗЗНДНТУТХ	Монгол, Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ТЗУ	Төрийн захиргаа удирдлага
ХОХБТ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлт
ЖГҮ	Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
БХБГ	Барилга, хот байгуулалтын газар
МЭГ	Мал эмнэлгийн газар
ЗГ	Засгийн газар

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

*Аудит хийх үндэслэл,
бүрэн эрх:*

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан аудитын төлөвлөгөө, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу “Олон улсын байгууллагаас орон нутагт хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилт, үр нөлөө”-нд өөрийн санаачилгаар гүйцэтгэлийн аудит хийлээ.

Аудитын зорилт:

Олон улсын байгууллагаас орон нутагт хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилт үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, илэрсэн зөрчил дутагдлыг заасан хугацаанд нь арилгуулж, гадаадын төсөл арга хэмжээг эдийн засгийн хувьд үр өгөөжтэй хэрэгжүүлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- ❖ Олон Улсын байгууллагаас хэрэгжүүлэх төслийг орон нутгийн бодлого, төлөвлөлтөд нийцүүлэн төлөвлөсөн эсэх
- ❖ Олон Улсын байгууллагаас хэрэгжүүлж буй төслийг гэрээ, хэлэлцээрт заасан хугацаанд үр дүнтэй, хяналттай хэрэгжүүлсэн эсэх

*Аудитад
ашигласан
шалгуур
үзүүлэлт:*

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- ✓ Төсвийн тухай хууль;
- ✓ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- ✓ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль;
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- ✓ Засгийн газрын 2017 оны 176 дугаар тогтоолоор баталсан “гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах” журам;
- ✓ Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх” журам;
- ✓ Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 77 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам;
- ✓ Аудитын зорилго, зорилтод шаардагдах бодлогын болон хууль эрх зүйн бусад баримт бичгүүд
- ✓ 2016-2020 онд Монгол улсын ЗГ-ын шугамаар, гадаадын зээл тусламжаар хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн судалгаа, мэдээлэл

Аудитын хамарсан хүрээ:

Аудитыг олон улсын байгууллагын хөрөнгө оруулалтаар 2018-2020 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, ТАХ-ний төлөвлөлт, гүйцэтгэл, аймгийн хэмжээнд хийсэн судалгаа, шинжилгээний баримт материал, ажлын тайлан, ТАХ-ний зураг төсөл, магадлалын дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл болон гэрээний хэрэгжилтэд төсөл хэрэгжүүлэгч болон төрийн захиргааны байгууллага, аймгийн Засаг дарга, түүний харьяа байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан, баталгаажуулсан ажлын гүйцэтгэлд үндэслэн хийсэн.

Тус аудитад Дундговь аймагт төслийн ажилтнаараа дамжуулан ТАХ-г хэрэгжүүлсэн 5 төсөл хэрэгжүүлэх нэгжийн хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний төлөвлөлт, зарцуулалт хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтыг голчлон хамруулсан бөгөөд аймгийн төв болон Дэлгэрцогт суманд хэрэгжсэн ТАХ-ний гүйцэтгэлийг объект дээр нь очиж үзэн, хэмжилт хийж, зураг төсөлтэй тулгалт хийлээ.

Ковид-19 цар тахлын улмаас бусад сумдад ажиллах боломжгүй болж, хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын бодит гүйцэтгэлийг газар дээр нь шалгаагүй болно.

Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөрт дурдсан хугацаанд шалгах хуудсаар нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан.

*Аудит хийх багийн
бүрэлдэхүүн, хугацаа:*

Аудитын гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг аудитын менежер Х.Наранцацрал хянан удирдаж, үе шатны чанарын хяналт хэрэгжүүлэн, нийцлийн аудитын албаны ахлах аудитор Д.Ихбаяр, аудитор Д.Должинсүрэн нар 2021 оны 5 дугаар сарын 03-ны өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 26-ны өдрийг дуустал хугацаанд аудитыг гүйцэтгэлээ.

Хүндрэл бэрхшээл

Ковид-19 цар тахлын тархалт нэмэгдсэнтэй холбоотой тэг зогсолт хийгдсэнтэй холбоотой тайлангийн төсөл бэлтгэх ажил аудитын хөтөлбөрийг баримталж ажиллахад хүндрэлтэй байсан болно.

Аудитын дүн

Аудитаар нийт 329.2 сая төгрөгийн зөрчил илрүүлж, аудитын явцад 1.5 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулж, 327.7 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар 12 байгууллагад хугацаатай албан шаардлага, 9 заалт бүхий зөвлөмж хүргүүллээ.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Дундговь аймгийн хэмжээнд 2018-2020 оны хооронд нийт **18,467.2** сая төгрөгийн олон улсын хөрөнгө оруулалттай төсөл хөтөлбөрүүд хэрэгжсэн байна.

График № 1



Олон улсын байгууллагуудаас 2018 онд **1,309.3** сая төгрөг, 2019 онд **1,034.9** сая төгрөг, 2020 онд **16,123.0** сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Хөрөнгө оруулалт, ТАХ-ний 8.0 хувь нь хөдөө аж ахуйн салбарт, 8.5 хувь нь эрүүл мэндийн салбарт, 3.2 хувь нь боловсролын салбарт, **70.4** хувь нь дэд бүтцийн салбарт, 10 хувь нь бусад салбарт хийгдсэн байна.

Хөрөнгө оруулалт, ТАХ-ний дийлэнх хувийг Дэлхийн банк болон Азийн хөгжлийн банк, Швейцарын

хөгжлийн агентлагийн тусламжаар хэрэгжсэн төслүүд эзэлж байна. Боловсролын салбарт дээрх 2 банк болон “Арабын Нэгдсэн Эмират улсын элчин сайдын яамны тусламж”, БНСУ-ын Keimyung соёлын их сургууль, Японы Өвсний үндэс хөтөлбөр зэрэг ОУ-ын байгууллагуудаас, Хөдөө аж ахуйн салбарт “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл”, Эрүүл мэндийн салбарт Францын аксиом монгол нийгэмлэгийн хамтын ажиллагаа, “Япон улсын Өвсний үндэс”, “Дэлхийн эрүүл мэндийн байгууллага зэрэг ОУ-ын байгууллагууд төсөл хэрэгжүүлсэн байна. /Хавсралт №1-5/

Дундговь аймагт төслийн ажилтнаараа дамжуулан ТАХ-г хэрэгжүүлдэг 5 төсөл байна.

Үүнд:

“Гамшигт тэсвэртэй орон нутаг” төслийг Дэлхийн Зөн Монгол Олон улсын байгууллагаас 2020-2022 онд Увс, Говь-Алтай, Орхон, Чойбалсан, Улаанбаатар, Дорноговь, Дундговь гэсэн 7 аймагт хэрэгжүүлж байна. Тус төсөл нь Дундговь аймгийн Дэрэн, Гурвансайхан, Сайнцагаан сумдад хэрэгжинэ.



1. Төслийн зорилго нь иргэдийн амьжиргааг хамгаалах, мал аж ахуйн салбарт гамшгийн эрсдэлийг бууруулах, хот суурин газрын гамшгийн эрсдэлийг бууруулах, даван туулах чадавхыг бэхжүүлэх замаар орон нутагт тохиолдож болзошгүй гамшгийг эрсдэлийг үе шаттайгаар бууруулах.
2. Төслийн санхүүжилт: 1.3 сая доллар / нийт 7 аймгийн төслийн дүн/
3. Төслийн хэрэгжилт: Ковидын нөхцөл байдлын улмаас төслийн ажил эхлээгүй байна. Харин мал аж ахуйн салбарт гамшгийн эрсдэлийг бууруулах хэд хэдэн сургалт зохион байгуулсан. Мөн Дэрэн сумын Эрдэм шинжилгээ туршилт үйлчилгээний газрыг түшиглэн малын тэжээлийн ургамал тарихаар судалгааны ажлын бэлтгэл хийгдэж байна.

“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийг Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн хооронд 2017 онд байгуулсан Санхүүжилтийн хэлэлцээрийн дагуу нэмэлт санхүүжилтээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамаар дамжуулан 9 аймагт 2018-2022 онд хэрэгжүүлж байна. Дундговь аймгийн Дэлгэрцогт, Эрдэнэдалай, Сайхан-Овоо, Сайнцагаан сумдад голчлон хэрэгжиж байна.



1. Төслийн зорилго нь Хөдөөгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, амьжиргааг тогтвортой дээшлүүлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газар болон Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан (IFAD)-гаас тавьсан зорилго, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.
2. Төслийн санхүүжилт: Дундговь аймагт 2019 онд 275.3 сая төгрөгийн 3 нэр төрлийн ТАХ-г 100 хувь төслөөс, 2020 онд өмнөх оноос 3.8 дахин их буюу 1,064.7 сая төгрөгийн ТАХ-г хэрэгжүүлснээс 30 хувь буюу 310.9 сая төгрөгийг ОНХС-гаас, 70 хувь буюу 753.8 сая төгрөгийг төслөөс санхүүжүүлсэн байна.

3. Төслийн хэрэгжилт: Төслийн хүрээнд 14 суманд 23 гүний худаг, 22 мал угаалгын ванн, төсөл хэрэгжүүлэгч 3 суманд 28 энгийн уурхайн худаг засвар, оготно устгалын тоног төхөөрөмж, 3 өвс, тэжээлийн саравч агуулах, өвс, тэжээл, малчдын хөгжлийг дэмжих танхимын тоног төхөөрөмж, ажлын байр нэмэгдүүлэх 4 байрны засвар зэрэг ажлуудыг хэрэгжүүлсэн байна.

“Ногоон алт, малын эрүүл мэнд” төслийг Швейцарын хөгжлийн агентлагаас 2017-2020 оны хооронд 18 аймагт хэрэгжүүлэхээр байсан. Ковид-19 цар тахалтай холбоотой 2019-2020 онд үйл ажиллагаа удаашралтай байсан учир 2021 онд сунгаж хэрэгжүүлэхээр болсон. Дундговь аймгийн Хулд, Сайхан-Овоо, Дэлгэрхангай, Адаацаг, Сайнцагаан сумд төсөл хэрэгжиж байна.



1. Төслийн зорилго нь бэлчээрийн газрыг сумын тусгай хэрэгцээнд авч, бэлчээрийн зааг, хил хязгаарыг газрын зурагт тусган, бэлчээрийг хамгаалах, малчдын бэлчээр ашиглалтыг сайжруулах.
2. Төслийн санхүүжилт: Дундговь аймагт төслийн үйл ажиллагаанд 77.6 сая төгрөг зарцуулсан.
3. Төслийн хэрэгжилт: “Элгэмсэг Дундговь” ТББ-тай хамтран аймгийн “Бэлчээр ашиглах журмын төсөл”-ийг боловсруулан малчдын зөвлөгөөн, БИНХ, төрийн болон төсөл хөтөлбөрийн байгууллагууд, 15 сумын төлөөлөл зэрэг 3 удаагийн хэлэлцүүлгээр нийт 1,642 иргэдийг оролцуулан, төслийг хэлэлцүүлэн, 100 хувь дэмжигдэж, ИТХТ-ийн хурлаар хэлэлцүүлж, батлуулах ажил хийгдэж байна. Мөн 6 суманд бэлчээр ашиглагчдын холбоо, 30 бэлчээр ашиглагчдын хэсэг байгуулан, Өлзийт, Хулд, Сайхан-Овоо, Адаацаг сумд суурь судалгааны зураглалыг Arc GIS программд бүрэн хамруулж, бэлчээрээ хуваарьтайгаар ашиглах, бэлчээрийн зааг, хил хязгаарыг газрын зурагт тусгаж, тусгай хэрэгцээнд авсан.

“МЕРИТ” Канад Улсын Гадаад хэргийн яамны санхүүжилттэй Канадын мэргэжлийн үйлчилгээний байгууллага болон Канадын дэлхийн их сургуулийн үйлчилгээ гэх 2 төрийн бус байгууллагын консорциумаар 7 жил /2016-2023/-ийн хугацаанд хэрэгжиж байгаа төсөл.



1. Төслийн зорилго нь орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн сайн туршлага, арга зүй тогтолцоог байгууллагын үндсэн үйл ажиллагааны байнгын хэм хэмжээ болгон тогтоох зорилгоор богино болон урт хугацааны техникийн зөвлөхөөр дамжуулан мэдлэг, ур чадварыг үр дүнтэй уялдуулах буюу чадавх бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллах.
2. Төслийн санхүүжилт: 82.0 сая төгрөг
3. Төслийн хэрэгжилт: 11 түншлэгч байгууллагад дэмжлэг үзүүлж, нийт 95 зөвлөх урьж сургалт зохион байгуулан, олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх замаар нийт 1000 гаруй /үүнээс 585 нь эмэгтэй/ иргэдийг сургалтад хамруулсан.

“Тогтвортой амьжиргаа-3” төслийг Дэлхийн банк, Швейцарын хөгжлийн агентлаг болон Сангийн яам хамтран “Тогтвортой амьжиргаа” төслийн гурав дахь үе шатыг 2018- 2021 онд хэрэгжүүлж байна.



1. Төслийн зорилго: Төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд олон нийтийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх замаар 2011 онд батлагдсан Төсвийн тухай хуулийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх.
2. Төслийн санхүүжилт: 1,704.5 сая төгрөг /2018-2020/
3. Төслийн хэрэгжилт: Дундговь аймгийн 15 сумын төсөв, санхүүгийн удирдлага, “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн үйл ажиллагаанд төслөөс боловсруулсан зааварчилгааны дагуу сумдын засаглалын түвшнийг жил бүр үнэлдэг байна. Энэхүү “Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ”/ЖГҮ/-г гүйцэтгэсэн хөндлөнгийн байгууллагын дүгнэлтэд үндэслэн, тодорхой болзол хангасан сумдад “урамшуулал” олгодог бөгөөд энэ хэмжээгээрээ ОНХС-ийн санхүүжилт нэмэгдэж байна. Мөн 2018 оноос хэрэгжиж эхэлсэн төслийн нэг онцлог нь жил болгон бүх сумын ОНХС-д тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлдэг болсон байна.

График товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	2018-2020 оны хооронд Дундговь аймагт хэрэгжсэн ОУ-ын төсөл хөтөлбөр	10
График 2	Бэлчээр усжуулалтын хувь	12
График 3	Мал угаалгын ванн судалгаа	12

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Засгийн газрын шугамаар гадаадын зээл болон тусламжаар 2016-2020 онд хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн судалгаа	13
Хүснэгт 2	Орон нутагт эрх нь шилжиж ирсэн ТАХ-ний худалдан авах ажиллагаа	14
Хүснэгт 3	ЖГҮ-гээр хангалтгүй үнэлэгдэж, урамшуулалд хамрагдаагүй сумд болон авах "боломж" -той байсан санхүүжилтийн дүн	15

Зураглалын товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураглал 1	Сумдад хэрэгжиж байгаа ОУ-ын байгууллагын төслүүд	11
Зураглал 2	Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл"-өөс хэрэгжсэн ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байдал	14

Хавсралтын товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Дундговь аймгийн боловсролын салбарт олон улсын байгууллагаас 2018-2020 онд хэрэгжсэн төсөл хөтөлбөр	25
Хавсралт 2	Дундговь аймгийн эрүүл мэндийн салбарт олон улсын байгууллагаас 2018-2020 онд хэрэгжсэн төсөл хөтөлбөр	25
Хавсралт 3	Дундговь аймгийн хөдөө аж ахуйн салбарт олон улсын байгууллагаас 2018-2020 онд хэрэгжсэн төсөл хөтөлбөр	26
Хавсралт 4	Дундговь аймгийн бусад салбарт олон улсын байгууллагаас 2018-2020 онд хэрэгжсэн төсөл хөтөлбөр	26
Хавсралт 5		
Хавсралт 6	Зах зээл ба бэлчээрийн удирдлагын төслөөр хэрэгжсэн төслийн бүртгэл тайланд мэдээлэгдсэн байдал /2018-2020 онд хэрэгжсэн төсөл хөтөлбөр	27
Хавсралт 7	Дундговь аймагт засгийн газрын шугамаар гадаадын зээл болон тусламжаар 2016-2020 онд хэрэгжсэн төсөл хөтөлбөр	28
Хавсралт 8	Тогтвортой амьжиргаа төслөөс сумдын ОНХС-ийн үйл ажиллагаанд хийсэн жилийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн ба олгосон урамшууллын судалгаа	29



БҮЛЭГ А. ГАДААДЫН ЗЭЭЛ ТУСЛАМЖААР ТАХ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР ОРОН НУТАГТ БАРИМТЛАХ НЭГДСЭН ХӨТӨЛБӨР БАЙХГҮЙ, ТӨЛӨВЛӨЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

А.1 ДУНДГОВЬ АЙМАГ ГАДААД ХАРИЛЦААНД БАРИМТЛАХ НЭГДСЭН ХӨТӨЛБӨР, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БАЙХГҮЙГЭЭС ЗАСГИЙН ГАЗРЫН БОЛОН БУСАД ШУГАМААР ХЭРЭГЖИЖ БУЙ ТАХ-Г ОРОН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛОМЖИЙГ АЛДЖЭЭ.



Дундговь аймагт гадаад харилцаанд баримтлах нэгдсэн хөтөлбөр, зохион байгуулалт байхгүй байна.

Аймгийн ЗДТГ нь УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2011 оны 10 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал” –ын бичиг баримтыг үндэслэн гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээрх үйл ажиллагаагаа зохион байгуулж, харин аймгийн гадаад харилцаанд баримтлах нэгдсэн хөтөлбөргүй ажиллаж ирсэн байна.

Энэ нь аймгийн гадаад харилцааны нэгдсэн хөтөлбөрийн төлөвлөлт хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллах хэлтэс агентлагуудын чиг үүрэг, хариуцлагын тодорхой бус байдлыг бий болгож, түүнээс шалтгаалж гадаад орнуудтай тогтоосон хамтын ажиллагаагаа өргөжүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ажлын үр нөлөө буурах эрсдэлтэй байгааг харуулж байна.

“

Сайн туриллага: Өвөрхангай аймаг Аймгийн ИТХТ-ын 2017 оны 57 дугаар тогтоолоор “Аймгийн гадаад харилцаанд баримтлах бодлого”, “Албан ажлаар гадаадад ажиллах” журам, “Гадаад харилцааны аймгийн зөвлөлийн ажиллах” журмыг тус тус батлан хэрэгжүүлэн ажиллаж байна.

”

Иймд аймгийн “Гадаад харилцаанд баримтлах хөтөлбөр, чиглэл”-ийг боловсруулан, түүний хэрэгжилтэд хяналт тавьж, аймгийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны үр ашиг, үр нөлөөг нэмэгдүүлж ажиллах шаардлагатай байна.



Засгийн газрын шугамаар хэрэгжсэн 9 төсөл арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлж, 62 төсөл арга хэмжээг орон нутагт хэрэгжүүлэх боломжийг алдсан байна.

Аймгийн ЗДТГ-аас /Төрийн захиргаа удирдлагын хэлтэс/ гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх асуудлаар төрийн байгууллагуудыг нэгдсэн бодлого чиглэлээр хангаж хамтран ажиллаагүйгээс тэдгээр байгууллагууд өөрсдөө хөөцөлдөж гадаадын хөрөнгө оруулалтын ТАХ-нд хамрагдаж байна. Тухайлбал: Аймгийн ЗДТГ болон бусад хэлтэс агентлагууд аймгийн онцлогт тохирсон, хэрэгцээ шаардлагад нийцсэн, хэрэгжүүлж болох төслийн судалгаагүй, өмнө хэрэгжсэн төслийн мэдээллийг нэгтгэн боловсруулж дүн шинжилгээ хийгээгүй байсан.

Монгол Улсад Засгийн газрын шугамаар гадаадын зээл болон тусламжаар 2016-2020 онд **602 ТАХ** хэрэгжиж, **495 ТАХ** нь хэрэгжиж дууссан **107 ТАХ** нь одоогоор хэрэгжиж байна. /Хүснэгт № 1/

Дээрх **602 ТАХ**-үүдээс **71 ТАХ** нь манай аймгийн онцлогт тохирч байгаа бөгөөд

үүнээс 9 ТАХ хэрэгжсэн нь аймгийн онцлогт тохирсон, хэрэгцээ шаардлагад нийцсэн үр дүнтэй хөрөнгө оруулалт болж чадсан байна.

Гэвч 71 ТАХ -нээс 9 ТАХ-г хэрэгжүүлсэн нь орон нутгаас төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудтай харилцах хамтын ажиллагаа дутмаг, ажлын хариуцлагагүй байдлаас шалтгаалж, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлэх боломжгүй ТАХ-г гадаад эх үүсвэрээс шийдвэрлэх боломжийг алдсан байна.

Мөн аймаг, сумын төрийн байгууллагууд Засгийн газрын шугамаар бус, гадаадын зээл тусламжаар хэдий хэмжээний хөрөнгө оруулалт ТАХ хэрэгжүүлэх боломжийг алдсан нь тодорхой бус байна. Хавсралт № 7

Хүснэгт № 1¹

Засгийн газрын шугамаар гадаадын зээл болон тусламжаар 2016-2020 онд хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн судалгаа /сая. төгрөг/						Нийт төсөл хөтөлбөр	Хэрэгжиж дууссан	Хэрэгжиж байгаа
Гадаад зээл		Гадаад тусламж		Дамжуулан зээл				
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Тоо	Тоо
268	19,706,075.5	67	490,873.0	267	2,551,380.2	602	495	107

Энэ нь аймгийн хэмжээнд гадаад харилцаанд баримтлах нэгдсэн хөтөлбөр, зохион байгуулалт байхгүй, ЗДТГ болон бусад хэлтэс, агентлагууд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлэх боломжгүй ТАХ-ний хэрэгцээ шаардлагыг судалж, олон улсын төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр шийдвэрлэх арга замыг тодорхойлох, эрэлхийлэх ажил хангалтгүй, төрийн байгууллага хоорондын ажлын уялдаа холбоо муу байгаатай холбоотой байна.

Иймд аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргаа удирдлагын хэлтэс нь Монгол Улсад Засгийн газрын болон бусад шугамаар хэрэгжиж байгаа гадаадын зээл, тусламжийн мэдээллийн нэгдсэн баазыг аймагтаа бий болгон, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлэх боломжгүй ТАХ-г гадаад эх үүсвэрээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн бодлогоор хангах ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

¹ Мэдээллийн эх сурвалж: Үндэсний аудитын газрын 3-дугаар газарт Сангийн яамнаас хүргүүлсэн Засгийн газрын шугамаар гадаадын зээл болон тусламжаар 2016-2020 онд хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн гүйцэтгэлийн судалгаа

А.2 ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР ХИЙХ АЖЛЫГ АЙМГИЙН УРТ БОЛОН ДУНД ХУГАЦААНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БОДЛОГОТОЙ УЯЛДУУЛАН, НАРИЙВЧЛАН ТӨЛӨВЛӨЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ ХАНГАЛТГҮЙ БАЙСАН БАЙНА.



Төсөл хэрэгжүүлэх нэгжүүд ТАХ-г хэрэгжүүлэх сумдыг төслийн зорилго, зорилтын дагуу сонгож, шаардлагатай ТАХ-г санхүүжүүлсэн боловч зарим сумдын идэвх оролцоо муу байна.

Дундговь аймагт төслийн ажилтнаараа дамжуулан ТАХ-г хэрэгжүүлдэг 5 төслөөс “Тогтвортой амьжиргаа төсөл III”, “МЕРИТ” төслийн хувьд аймаг сумдыг бүрэн хамруулан үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна. Харин бусад төслийн хувьд дараах сумд төслийн зорилтот сумаар сонгогдсон байна.

Зураглал № 1 Сумдад хэрэгжиж байгаа ОУ-ын байгууллагын төслүүд



Дэрэн
Сайнцагаан
Гурвансайхан



Хулд, Сайхан-Овоо,
Дэлгэрхангай, Адаацаг,
Сайнцагаан



Сайхан-Овоо
Дэлгэрцогт
Эрдэнэдалай

Төсөл хэрэгжүүлэх зорилтот сумыг сонгох ажилд орон нутгийн байгууллагын оролцоо бага, төсөл хэрэгжүүлэгч байгууллага өөрсдийн үйл ажиллагааны чиглэлээр урьдчилсан судалгаа, шинжилгээ хийж, эрсдэлд суурилан хэрэгжүүлэх сумдыг сонгосон байна. Харин Дэлхийн зөн олон улсын байгууллага “Гамшигт тэсвэртэй орон нутаг” төслийг хэрэгжүүлэх, зорилтот сумдыг орон нутгийн хэрэгцээ шаардлага, тухайн салбар хариуцсан хэлтэс, агентлагуудын саналыг харгалзан сонгосон байна.

“Гамшигт тэсвэртэй орон нутаг” төсөл 2021 онд Дэрэн сумын “Эрдэм шинжилгээ туршилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ыг түшиглэн 91.7 сая төгрөгийн “Малын тэжээлийн ургамал тариалах” төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь төсөл хэрэгжүүлэх сумын сонголт оновчтой байна.

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл 2018, 2019 онд сонгогдсон 4 суманд хэрэгжиж 2020 оноос орон нутгийн оролцоог нэмэгдүүлж */Төслөөс 70 хувь, орон нутгаас 30 хувийн санхүүжилт/* мал угаалгын ванн барих, инженерийн хийцтэй худаг гаргах ажилд бүх сумдыг хамрагдах боломжийг олгосон бөгөөд орон нутгаас гаргах санхүүжилтийн боломжоос хамаарч Дэлгэрхангай сумаас бусад сумд бүрэн хамрагдаж харилцан адилгүй хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Орон нутгаас санхүүжүүлэх 30 хувийн санхүүжилтийг ихэнх сумд ОНХС-ийн хөрөнгөөр, зарим сумд мал эмнэлэг, малчин иргэдийн хандив тусламжаар шийдвэрлүүлсэн байна.

“

Сайн жишээ: Гурвансайхан, Дэрэн, Сайхан-Овоо сумд Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн хүрээнд хийгдэх ажлын орон нутгаас санхүүжүүлэх 30 хувийн хөрөнгийн тодорхой хувийг хувийн мал эмнэлэг болон малчин иргэдийн хандив тусламжаар шийдвэрлэж хөрөнгө оруулалтыг (800.0 мянгаас -17,700.0 мянган төгрөг) нутагтаа авч чадсан.

”

Аудитын явцад сумдын худаг ус, бэлчээрийн усан хангамжийн хүрэлцээ, малыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажилд шаардагдах тоног төхөөрөмжийн хэрэгцээ шаардлагыг сумдад хийгдсэн хөрөнгө оруулалттай харьцуулсан судалгаа хийхэд хөрөнгө оруулалтыг хэрэгцээ шаардлагад тулгуурлан хийгээгүй байна.

Аймгийн ХХААГ-ын 2020 онд хийсэн судалгаагаар аймгийн хэмжээнд бэлчээрийн усан хангамж 50.3 хувьтай буюу 49.7 хувийн дутагдалтай байна.

График 2–т үзүүлснээр Сайнцагаан сумын бэлчээрийн усжуулалт хангалттай буюу 106.3 хувь, Говь-Угтаал, Баянжаргалан, Цагаандэлгэр, Луус, Эрдэнэдалай, Адаацаг сумдын бэлчээрийн усжуулалт 60.5 -86.1 хувьтай, бусад сумдын бэлчээрийн усжуулалт 19.5-46.7 хувьтай буюу Сайнцагаан сумаас бусад бүх сумдад шинээр худаг барьж бэлчээрийг усжуулах шаардлагатай байгааг харуулж байна.

График № 2²

Баянжаргалан, Цагаандэлгэр, Дэлгэрхангай сумдад худаг гаргах шаардлага байсан боловч орон нутгаас санхүүжүүлэх 30 хувийг бүрдүүлж чадаагүйгээс Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслөөр худаг гаргах ажил огт хийгдээгүй байна.

Мөн мал угаалгын ванны хэрэгцээ шаардлагыг судлахад 12 суманд 29 мал угаалгын ванн дутагдалтай байна. Судалгааг график 3-аар харууллаа. Үүнд:



График № 3³




График 3–т үзүүлснээр 2019-2021 онд **Хулд, Луус, Дэлгэрхангай** сумаас бусад суманд Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслөөр 1-4 ванн хийгдсэн хэдий ч **Дэлгэрцогт, Цагаандэлгэр, Баянжаргалан** сумдаас бусад сумдад 1-7 мал угаалгын ванн дутагдалтай байна. 2020 онд Хулд суманд 1 мал угаалгын ванн хийгдэхээр төлөвлөгдсөн боловч мал угаалгын ванн барих газрын асуудлаа шийдвэрлээгүйгээс шалтгаалж Сайнцагаан суманд шилжүүлэн барьсан байна. Энэ нь тус сумын

² Мэдээллийн эх сурвалж: Аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газраас 2020 онд хийгдсэн худаг ашиглалт бэлчээрийн усжуулалтад хийсэн судалгааны тайлан

³ Мэдээллийн эх сурвалж: Аймгийн мал эмнэлгийн газар болон сумдын мал эмнэлгийн тасгийн ирүүлсэн мэдээлэл үндэслэн боловсруулав.

ЗДТГ-ын ажил хариуцсан ажилтнуудын хариуцлагагүй байдлаас шалтгаалж малыг эрүүлжүүлэх мал угаалгын ваннтай болох боломжийг алдаж байна.

Дэлгэрхангай суманд төслийн оролцоотой санхүүжилтээр огт ажил хийгдээгүй нь тухайн сумын бэлчээрийн усан хангамж, малыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажил бүрэн хангагдсандаа биш харин сумын удирдлагууд тус салбарын ажилд ач холбогдол өгөхгүй хариуцлагагүй хандаж, орон нутагтаа төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр шаардлагатай хөрөнгө оруулалт хийгдэх боломжийг алдсан байна.

Иймд худаг ус, бэлчээрийн усан хангамжийн дутагдал, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажилд шаардагдах тоног төхөөрөмжийн хэрэгцээ шаардлагыг нарийвчлан тодорхойлж, түүний үндсэн дээр хөрөнгө оруулалтын ажлыг дэс дараалалтай төлөвлөж, цаашид төсвийн хөрөнгөөс бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх боломжийг алдахгүй байхад анхаарч ажиллах шаардлагатай байна.



Дундговь аймаг 2018-2020 онд гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр хийх ажлыг аймгийн урт болон дунд хугацаанд хэрэгжүүлэх бодлогын баримт бичигт тусгасан боловч жилийн төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй байна.

Гадаад орнуудтай тогтоосон хамтын ажиллагаагаа өргөжүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр хийгдэх ажлыг “Аймгийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө 2012-2031” болон “Дундговь аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн хөтөлбөр 2018-2028” дунд хугацааны бодлогын баримт бичиг, 2016-2020 оны Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгасан боловч тухай жилийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд нарийвчлан тусгаагүй, 2018-2020 онд аймгийн гадаад, харилцаа хамтын ажиллагааны жилийн төлөвлөгөөгүй ажилласан байна.

Дундговь аймагт төслийн ажилтнаараа дамжуулан ТАХ-г хэрэгжүүлдэг 5 төслийн төсөл хэрэгжүүлэх нэгжүүд аймгийн Засаг даргатай жил бүр хамтран ажиллах гэрээ байгуулан гэрээний дагуу ТАХ-гээ хэрэгжүүлж байна.

Дээрх байдлаас харахад гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр хийх ажлыг аймгийн урт болон дунд хугацаанд хэрэгжүүлэх бодлоготой уялдуулан нарийвчлан төлөвлөж хэрэгжүүлэхгүй байна.

Энэ нь сүүлийн жилүүдэд аймгийн гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан ажилтан байхгүй, ажлыг мэргэжлийн бус хүнд хавсруулан гүйцэтгүүлж байсантай холбоотой бөгөөд гадаад харилцааны чиглэлээр урт болон дунд хугацаанд төлөвлөгдсөн ажлууд үр дүнтэй хийгдэхгүй байх эрсдэлийг бий болгосон байна.

Иймд гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан ажилтныг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжоор хангаж ажиллах хэрэгтэй байгааг харуулж байна.

2020 оны 11 сараас хариуцсан ажилтантай болсноор гадаад харилцааны бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр олон ажлуудыг зохион байгуулж, 2021 онд гадаад харилцаа хамтын ажиллагааны чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Цаашид аймгийн урт хугацааны хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө, 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засаг даргын мөрийн хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигтэй уялдуулан жил бүр гадаад орнуудтай тогтоосон хамтын ажиллагаагаа өргөжүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх ажлыг бодитой төлөвлөж байх шаардлагатай байна.

БҮЛЭГ Б. ТАХ-Г ГЭРЭЭ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ДАГУУ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОЛОВЧ, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВЬЖ ҮР ДҮНГ ТООЦОЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

Б.1. ТӨСЛИЙН БАТЛАГДСАН ХӨРӨНГИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.



Олон Улсын байгууллагаас хэрэгжүүлж буй төслийн худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.

Олон улсын байгууллагаас 2018-2020 оны хооронд хэрэгжсэн ТАХ-ний худалдан авах үйл ажиллагааг шалгахад “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл”-ийн худалдан авах ажиллагааны дийлэнх буюу 92 хувийг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчид эрх шилжүүлэн, зохион байгуулж ажилласан байна.

Харин бусад олон улсын байгууллагаас хэрэгжсэн ТАХ-ний худалдан авах ажиллагааг тухайн орон нутагт хамааралгүй зохион байгуулж, төслийг хэрэгжүүлсэн байна.

Зураглал №2 “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл”-өөс хэрэгжсэн ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байдал /сая төгрөг/



Дундговь аймагт 2019 онд эрх шилжиж ирсэн 178.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ, 2020 онд 1,189.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулж, ТАХ-г хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт №2 Орон нутагт эрх шилжиж ирсэн ТАХ-ний худалдан авах ажиллагаа /сая.төгрөг/

ХАА /он	Хуулийн дагуу				Амжилттай				Амжилтгүй		ХАА зөрчсөн	
	2019		2020		2019		2020		2020		2020	
	Багц	Дүн	Багц	Дүн	Багц	Дүн	Багц	Дүн	Багц	Дүн	Багц	Дүн
Нээлттэй			9	1,011.6			8	818.6	1	193.0		
Харьцуулалт	4	178.4	5	140.4	4	178.4	3	100.4			2	40.0
Шууд гэрээ			6	37.3			3	23.3	3	14.0		
Нийт	4	178.4	20	1,189.3	4	178.4	14	942.3	4	207.0	2	40.0

2020 онд нийт 3 ТАХ-ний 1,011.6 сая төгрөгийн 9 багцын ХАА-г нээлттэй тендер шалгаруулалтын аргаар хуулийн дагуу зохион байгуулснаас 9 багц тендер амжилттай зохион байгуулагдсан. Гэвч Гурвансайхан, Говь-Угтаал, Өндөршил, Дэрэн сумдад "Инженерийн хийцтэй худаг шинээр барьж, байгуулах ажил"-ын багц №3 тендерийн /193.0 сая төгрөг/ гүйцэтгэгчээр шалгарсан “Топ Дрилинг” ХХК ажлын явцад гэрээг цуцлуулах хүсэлт гаргаснаар захиалагч байгууллага тендерийг хүчингүй болгож, тухайн ондоо дахин тендер зарлаж амжихгүй болсон тул тендерийг 2021 онд дахин зарлахаар шийдвэрлэсэн

байна.

Малчны бүлгийн дэмжлэг буюу энгийн уурхайн худаг засварлах нийт 14.0 сая төгрөгийн 3 суманд хэрэгжих ТАХ-ний санхүүжилт оны сүүлээр оройтож ирснээр ТАХ-г хэрэгжүүлэх боломжгүй болж, засварыг 2021 оны хавар хийхээр хойшлогдсон байна.

Мөн 2020 онд 140.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ТАХ-ний 5 багц ажлын ХАА-г харьцуулалтын аргаар зохион байгуулахаас Сайхан-Овоо, Эрдэнэдалай сумд “Малын эрсдэлийн сан”-ийн 2 багц нийт 40.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ-ний ХАА-г хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, шууд худалдан авалт хийсэн зөрчил илэрсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1⁴, 33 дугаар зүйлийн 33.2.1⁵, Монгол улсын Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолын хавсралт⁶ -д /тухайн үед мөрдөгдөж байсан/ заасныг тус тус зөрчсөн байна.

Аудитаар худалдан авах ажиллагааны баримт материалын бүрдлийг шалгахад Дэлгэрцогт сумын “Өвс тэжээлийн агуулах саравч засварлах ажил” Багц 3 тендерийн 75.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил, “Ажилчдын байр засварлах ажил” Багц 4 тендерийн 50.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлуудын худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичигт заасны дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлээгүй байхад дээрх ажлуудын гүйцэтгэгчээр “Дөл БГМ” ХХК-ыг шалгаруулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 17 –т заасныг зөрчсөн тул худалдан авах ажиллагааг батлагдсан төсвийн хүрээнд хууль, журмын дагуу зохион байгуулах, тендерийн баримт бичигт заасан шаардлагыг хангасан компанийг шалгаруулж байх талаар аймгийн ОНӨГ-т хугацаатай албан шаардлага хүргүүлээ.

Худалдан авах ажиллагааны хууль, журмыг зөрчиж шууд худалдан авалт хийсэн нь холбогдох албан тушаалтнууд хууль журмаа бүрэн судлаагүй, ажилдаа хариуцлагагүй хандсан мөн ашиг сонирхлын зөрчил үүссэн байж болзошгүйг харуулж байна.



“Зах зээл ба бэлчээрийн удирдлага хөгжил” төслөөр нийлүүлсэн хөрөнгийн бүртгэл зөрүүтэй, түүний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.

Аудитаар Сайнцагаан, Дэлгэрцогт сумдын төсвийн байгууллагуудад хэрэгжсэн ТАХ-ны хэрэгжилтийг шалгахад боловсрол болон эрүүл мэндийн салбарын байгууллагууд төслөөс ирсэн хөрөнгийг бараа материал болон үндсэн хөрөнгийн дансандаа бүрэн бүртгэж, төслийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг ханган ажилладаг сайн туршлага байна.

Харин Дундговь аймагт хэрэгжиж байгаа дэд бүтэцтэй холбоотой төслүүдийн ихэнх нь хэрэгжилтийн шатандаа явж байгаа учир бүртгэл, тайланд тусгаагүй байна.

⁴ 8.1.-д /Засгийн газар нь барааны, ажлын, үйлчилгээний гэсэн ангилал тус бүрээр дараах босго үнийг тогтооно/ 8.1.2-т /Шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар/

⁵ 33.2. Харьцуулалтын аргыг дараахь байдлаар хэрэглэнэ: 33.2.1.үнийн санал ирүүлэх урилгыг энэ хуулийн 52.1.12, 53.5.4-т заасан худалдан авах ажиллагааны цахим системд зарлаж, үр дүнг тухай бүрд мэдээлэх;

⁶ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ/, хавсралтын 2–т /Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар нь бараа, ажлын хувьд – 10.0 сая/

⁷ 27.1.Тендер нээсний дараа тендер тус бүр нь дараах шаардлагыг хангасан эсхийг хянан үзнэ:

27.1.1.энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасныг үндэслэн захиалагчийн тогтоосон чадавхын шаардлага;

27.1.3.тендерийн баримт бичигт заасан бусад нөхцөл, шаардлага.

Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн хооронд байгуулсан хэлэлцээрийн дагуу “Зах зээл ба бэлчээрийн удирдлага хөгжил” төслөөр нийлүүлэгдсэн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, зөрүүтэй тайлагнасан дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- ❖ Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Адаацаг, Говь-Угтаал, Дэрэн сумд 2019-2020 онд хэрэгжүүлсэн гүн өрмийн худаг болон мал угаалгын ваннуудыг бүртгэл тайланд 55.6 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
- ❖ “Малчдын мэдээллийн төвийн тохижуулалт” төслийн хүрээнд 2019 онд Эрдэнэдалай, Дэлгэрцогт сумдад тус бүрд 5.0 сая төгрөгийн ширээ, сандал, нотебүүк, бусад тоног төхөөрөмж авч өгсөн боловч бүртгэл тайланд тусгаагүй;
- ❖ Дэлхийн зөн ОУБ-аас Боловсрол соёл, урлагийн газарт хандиваар өгсөн барилгыг 2019 онд “Жижиг дунд бизнес эрхлэгчдийн ажлын байрны засвар” төслийн хүрээнд 50.0 сая төгрөгөөр засварласан боловч тухайн барилгыг орон нутгийн өмчид бүртгэж аваагүй, ашиглалт хангалтгүй;
- ❖ Сайхан-Овоо, Эрдэнэдалай сумд 2020 онд “Малын эрсдэлийн сан” төслийн хүрээнд тус бүр 20.0 сая төгрөгөөр өвс тэжээл худалдан авсан боловч байгаль хамгаалах сангийн өвс, тэжээлийн борлуулалтын тооцоотой хольж, тусад нь бүртгэл тооцоо хөтлөөгүй, өвс тэжээлийн үлдэгдэл, авлагын тооцоог бодоогүй;
- ❖ 2019 онд төслөөс 100 хувь санхүүжүүлсэн Эрдэнэдалай сумын 1 худаг, Дэлгэрцогт сумын 1 худаг, 2020 онд Сайнцагаан суманд хийгдсэн 1 мал угаалгын ванныг бүртгэл, тайланд тусгаагүй;
- ❖ Төслөөр хийгдсэн мал угаалгын ванныг сумдын хувийн мал эмнэлгүүдэд, гүний худгийг нутгийн иргэдэд хүлээлгэн өгөхдөө хөрөнгө хүлээлцсэн акт үйлдэж, баталгаажуулаагүй, эд хариуцагчийн гэрээ хийгээгүй; /Хавсралт № 5/

Энэ нь ХХААХҮ-ийн сайдын 2019 оны “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” нэмэлт санхүүжилтийн төслийн хөрөнгө оруулалттай холбоотой харилцааг зохицуулах түр журмын 2.1⁸, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6.2⁹ -д заасныг зөрчсөн байна.

Дээрх зөрчлүүд нь аймгийн ЗДТГ-ын ТЗУ-ын хэлтсээс ирүүлсэн 2018-2020 онд хэрэгжсэн хандив, тусламжийн судалгаа, төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудаас ирүүлсэн судалгаа, аймгийн ЗДТГ-ын ХОХБТ-ийн хэлтэст бүртгэгдсэн хөрөнгө оруулалтын шинжтэй хандив, тусламжийн мэдээлэл болон төсөл хэрэгжсэн байгууллагуудаас ирүүлсэн бүртгэлийн судалгааны тулгалтаар илэрсэн.

Дээрх нөхцөл байдлаас дүгнэхэд аймгийн ЗДТГ-ын дэргэд ОУ-ын байгууллагаас хэрэгжсэн ТАХ-үүдийг нэгтгэн судалж, дүн шинжилгээ хийдэг, хэдий хэмжээний хандив, тусламж, ямар салбарт, ямар зорилго, зорилтын хүрээнд хэрэгжиж, ямар үр дүн, үр нөлөө үзүүлж байгаад хяналт тавьж, бодлогоор зохицуулалт хийдэг газар байхгүй байгааг харуулж байна. Энэ нь хандив, тусламжаар бий болсон аливаа хөрөнгөд тавих хяналт муудах, хөрөнгө эзэнгүйдэх, мөн шамшигдан, алга болох эрсдэлийг бий болгож байна.

Иймд дээрх зөрчлүүдийг арилгаж, зөрүүтэй бүртгэсэн хөрөнгийг залруулан бүртгэж,

⁸Төслийн хөрөнгө оруулалтаар барьж байгуулсан инженерийн хийцтэй худаг, цас борооны ус хуримтлуулах хөв, цөөрөм, тэжээлийн агуулах, өвсний саравч, хадлан бэлтгэх хадуур, тармуур, хаман боогч, тракторын иж бүрдэл, бог мал угаах угаалгын ванн, үлийн цагаан оготно устгах багаж, малчдад зориулж тохижуулсан мэдээллийн төв болон бусад сумын түвшинд хийгдсэн хөрөнгө оруулалтын эзэмшигч нь сумын Засаг даргын тамгын газар байна.

⁹Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна.

бүртгэлгүй хөрөнгийг нэмж бүртгэн, мэдээ, тайланд оруулах, өвс, тэжээлийн тооцоог эцсийн байдлаар гаргаж ирүүлэх талаар холбогдох сумдад хугацаатай албан шаардлага өгч, зөрчлийг арилгуулахаар шийдвэрлэлээ.



Олон улсын байгууллагын төслийн хөрөнгөөр худалдан авсан болон нийлүүлсэн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж байна.

Аудитыг гүйцэтгэх үед зарим суманд ковид-19 цар тахал гарсны улмаас Дэлгэрцогт, Сайнцагаан суманд хэрэгжсэн ОУ-ын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, ашиглалт, хадгалалт хамгаалалтыг шалгаж, бусад сумдын хувьд судалгааны түвшинд аудит хийлээ.

Боловсрол, эрүүл мэндийн салбарын байгууллагуудад ОУ-ын байгууллагаас хэрэгжсэн төсөл хөтөлбөр нь нарийн мэргэжлийн ур чадвар шаарддаг учир дадлагажуулах сургалтыг давхар хийж, төслийн хугацаа дууссан ч төслийн тогтвортой байдлыг ханган ажиллаж байна.

Хөдөө аж ахуйн чиглэлээр хэрэгжиж байгаа “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн хүрээнд хэрэгжсэн бичил бизнес эрхлэгчдийг дэмжих зорилготой хийгдсэн 79.5 сая төгрөгийн өртөгтэй төслөөр Эрдэнэдалай сумын Эм эргэлтийн сангийн хуучин байр, Дэлгэрцогт сумын хуучин ЗДТГ-ын байрыг засварласан боловч Эрдэнэдалай сумын барилга ашиглалтгүй, Дэлгэрцогт сумын барилгын ашиглалт зориулалт бус байна.

Иймд дээрх 2 сумдад бичил бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор засварлагдсан 2 барилгыг зориулалтын дагуу ашиглаж, үр ашгийг нэмэгдүүлэн, зөрчлийг арилгаж ажиллах талаар тухайн сумдын Засаг даргад албан шаардлага хүргүүлээ.

“

Сайн жишээ: Сайхан-Овоо суманд бичил бизнес эрхлэгчдийг дэмжих зорилготой “Ажлын байрны засвар”-ын ажилд төслөөс 35.0 сая төгрөг, орон нутгаас 5.0 сая төгрөгийн санхүүжилтээр 125м² ЗДТГ-ын өмчид бүртгэлтэй хуучин цэцэрлэгийн барилгад засвар хийсэн. Төслийн үр дүнд үсчин, цайны газар, цагаан идээ үйлдвэрлэл, хэрчсэн гурил, кофе шоп, эсгий гар урлал, талх нарийн боов зэрэг 7 нэр төрлийн бичил бизнес эрхлэх боломж нээгдсэн байна. Үүний сүү цагаан идээ, талх нарийн боов, хэрчсэн гурилын бизнесүүд нь тус төслөөс санхүүжиж байгаа 2 бүлгийн үйл ажиллагаа юм байна.

”

Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх хянах, тайлагнах журам” -ын дагуу “Дархан үйлс” ХХК, “Тааны амт” ХХК-уудын хийсэн нийт 10 мал угаалгын ванны захиалагчийн албаны хяналтыг Дундговь аймгийн Мал эмнэлгийн газар хийж, гэрээний дагуу 2,414.2 мянган төгрөг, 5 мал угаалгын ванны хяналтыг ГХБХБГ-ын БХБГ хийж, гэрээний дагуу 1,262.7 мянган төгрөг авч хяналт хийсэн байна.

Дархан Үйлс ХХК-ийн Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Сайнцагаан суманд мал угаалгын ванн хийсэн ажил сум болгонд харилцан адилгүй байна. Тухайлбал:

- Эрдэнэдалай, Сайнцагаан суманд хийсэн мал угаалгын ванны гүйдэг замыг эдэлгээ муутай дөрвөлжин төмрөөр хийсэн мөн хязгаарлагчийн төмөр нимгэн ямар ч эдэлгээгүй;
- Сайнцагаан суманд хийсэн ванны хана, шалны цемент бударч унасан, хагарсан муу цементээр хийсэн мал угаах боломжгүй учир ашиглаагүй;
- Сайхан-Овоо сумын 1 мал угаалгын ванны мал хаших 19 хашааг хүлээлгэж өгөөгүй;
- 2020 онд төслөөр хийгдсэн 15 мал угаалгын ванны ус сорох помпыг өгөөгүй ;
- Мал угаалгын ванныг сумдын хувийн мал эмнэлгүүдэд, гүний худгийг нутгийн иргэдэд хүлээлгэн өгөхдөө хөрөнгө хүлээлцсэн акт үйлдэж, баталгаажуулаагүй, эд

хариуцагчийн гэрээ хийгээгүй;

Энэ нь захиалагчийн хяналт тавьж байгаа байгууллага болон ажил хүлээлцэж авсан комисс хариуцсан ажилдаа хариуцлагагүй хандаж, чанар муутай, дутуу хийгдсэн ажлыг засаж залруулаагүй байхад нь хүлээн авснаас үүдэн гарсан зөрчил байна.

Иймд дутуу, чанаргүй хийгдсэн ажлыг гүйцэтгэгч байгууллагаар бүрэн гүйцэтгүүлж, дутуу нийлүүлэгдсэн ус сорох помп, малын хашааг авч, холбогдох сумдад хүлээлгэн өгч зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлагыг аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүллээ.

Б.2 ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААС ХЯНАЛТ ТАВИХ АЖИЛ ХИЙГДЭЭГҮЙ БАЙНА.



Төслийн жилийн үйл ажиллагааны тайлан, гэрээний хэрэгжилтийн үр дүнг жил бүр гарган, төслийн ажилтны гүйцэтгэлийг үнэлэн ажилласан байна.

Дундговь аймагт ТАХ-г хэрэгжүүлдэг зарим ОУ-ын байгууллагууд аймгийн Засаг даргатай жил бүр хамтран ажиллах гэрээ байгуулан, гэрээний дагуу ТАХ-гээ хэрэгжүүлж байна.

Аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээтэй ОУ-ын байгууллагуудын хувьд гэрээн дээрээ төслийн болон аймгийн хүлээх эрх, үүргийг тодорхой зааж, сар болгон төслийн үйл явцын тайлан болон гэрээний хэрэгжилтийг гаргуулан өгөхөөр заасан байдаг байна. Үүний дагуу төсөл хэрэгжүүлэгч болон төслийн мэргэжилтэн худалдан авалт болон гэрээний хэрэгжилтийн явц, гүйцэтгэлийн талаарх тайланг төсөл хэрэгжүүлэх нэгжид хүргүүлж, гэрээгээ дүгнүүлэн санхүүжилтээ тооцуулан авдаг байна.



Олон улсын байгууллагаас хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг шилэн дансны цахим хуудаст бүрэн мэдээлээгүй байна.

Олон улсын байгууллагаас хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүдийг шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байдлыг шилэн дансны сайттай тулган шалгахад “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн 2020 оны ОНХС-аас 30 хувийг гарган хийсэн ажлуудыг сумын ерөнхийлөн захирагчийн шилэн дансны хуудас орон нутгийн хөгжлийн сантай хамт мэдээлэгдсэн байна. 2019 оны “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн санхүүжилт болон бусад ОУ-ын байгууллагын санхүүжилтийг шилэн дансны цахим хуудаст мэдээлээгүй байна.

Иймд ОУ-ын байгууллагаас ирсэн хандив, тусламжийн мэдээллийг хууль, журмын дагуу хугацаанд нь мэдээлж байхыг төсөл хэрэгжсэн байгууллагуудад зөвлөж ажиллаа.



Төсөл хэрэгжүүлэгч нэгжүүдийн хяналтаар илэрсэн зөрчилд дүгнэлт хийж зөрчлийг арилгах, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажил хангалтгүй байна.

Дундговь аймагт төслийн ажилтнаараа дамжуулан төсөл арга хэмжээг хэрэгжүүлж байгаа байгууллагуудын төслийн зохицуулагч болон, төслийн хяналт-шинжилгээ, үнэлгээний хэсгүүд төслийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж явц, үр дүнг төслийн захирал болон удирдах хороонд танилцуулах зарчмаар хяналт хийгдэж байна.

Тухайлбал: 2020 онд ХХААХҮЯ-ны Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл хэрэгжүүлэгч нэгжээс Дундговь аймагт 2019 онд хийгдсэн хөрөнгө оруулалт, 2020 хийгдэж

буй хөрөнгө оруулалтад явцын болон гүйцэтгэлийн хяналт хийж аймгийн ЗДТГ, ХХААГ, МЭГ-т 11 заалт бүхий зөвлөмж өгсөн байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж биелэлтийг тооцоогүй, сумдад баригдсан мал угаалгын ванны бохирын нүх ухуулах ажил, ус соруулах, зайлуулах насос /помп/, зарим сумдын малын хашааны дутуу ажлыг хийлгэж хүлээн авах ажлууд хийгдээгүй хэвээр байна.

Энэ нь аймгийн Мал эмнэлгийн газраас тухайн асуудалд ач холбогдол өгөхгүй, хариуцлагагүй хандсанаас шалтгаалсан бөгөөд орон нутагт хийгдэж байгаа хөрөнгийн чанар, эдэлгээ, төслийн болон төсвийн хөрөнгө үр дүнгүй, үр ашиггүй зарцуулагдах эрсдэлийг бий болгож байна. Иймд мал угаалгын ванны барих ажлын хүрээнд нийлүүлэгдэх дутуу хөрөнгийг бүрэн хүлээн авч, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгч, төсөл хэрэгжүүлэх нэгжээс өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай байна.

Хүснэгт №3

№	Сумдын нэр	ЖГҮ-гээр хангалтгүй үнэлэгдэж, урамшуулалд хамрагдаагүй сумд болон авах "БОЛОМЖ" -той байсан санхүүжилтийн дүн /мян.төг/					Нийт дүн
		2016	2017	2018	2019	2020	
1	Дэлгэрцогт	21.2					21.2
2	Говь-Угтаал		31.5			12.2	35.2
3	Цагаандэлгэр		28.8		7.5	19.4	44.7
4	Өндөршил					40.0	40.0
5	Гурвансайхан	42.2	47.7		11.2		95.6
6	Өлзийт	33.4		8.7			42.1
7	Хулд			15.4			15.4
8	Дэлгэрхангай			15.3			15.3
9	Сайнцагаан	47.1					47.1
	Нийт						381.6

“Тогтвортой амьжиргаа -3 төсөл хэрэгжүүлэх нэгжийн хувьд Сумдын төсөв санхүүгийн удирдлагын бүтэн жилийн мөчлөг, “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн үйл ажиллагаанд “Тогтвортой амьжиргаа-3” төслөөс боловсруулсан зааварчилгааны дагуу сумдын засаглалын түвшинд 2016 оноос хойш жил бүр тасралтгүй үнэлгээ хийгдэж байна. Энэхүү “Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ”/ЖГҮ/-г гүйцэтгэсэн хөндлөнгийн байгууллагын дүгнэлтэд үндэслэн, тодорхой болзол хангасан сумдад “урамшуулал” олгодог бөгөөд энэ хэмжээгээрээ ОНХС-ийн

санхүүжилт нэмэгдэж байна. 2016 -2020 онд хийгдсэн ЖГҮ-ний үр дүнд аймаг сумын ОНХС-д нийт 1,119.5 сая төгрөгийн урамшуулал олгогдож орон нутгийн хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулсан байна. 2016-2020 онд хийгдсэн ЖГҮ түүний үр дүнг сумдаар судалж үзэхэд Дэрэн, Баянжаргалан, Луус, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Адаацаг сумд 5 жил дараалан буюу үнэлгээ хийж эхэлснээс хойш жил бүр урамшуулал авах болзлыг хангаж ажилласан байна. /Хавсралт № 6/

Харин бусад сумдын хувьд 1-3 жил хангалтгүй үнэлэгдэж төслийн санхүүжилтээр ОНХС-д буцалтгүй олгогдох урамшууллыг орон нутагтаа авах боломжийг алдсан байна. Хүснэгт :3 –ээс харахад Цагаандэлгэр, Гурвансайхан сумд 3 жил, Говь-Угтаал, Өлзийт сумд 2 жил, бусад сумд тус бүр 1 жил хангалтгүй үнэлэгдэж аймгийн дүнгээр нийт **381.6** сая төгрөгийн урамшуулал авах боломжийг алдсан байна. /ТА-3 төслөөс шалгуур хангасан сумдад урамшуулал олгодог аргачлалын дагуу тооцоолов./

Энэ нь сумдын Засаг дарга, ОНХС-ийн үйл ажиллагааг хариуцсан ажилтнууд сангийн үйл ажиллагаатай холбоотой хууль, журмын хэрэгжилтийг орон нутагт хангалтгүй зохион байгуулж байгаатай холбоотой бөгөөд ажилдаа хариуцлагагүй хандсан төрийн албан хаагч нарын буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан сум орон нутагт хийгдэх хөрөнгө оруулалтын хэмжээ буурч, иргэдийн амьдралд эерэг нөлөө үзүүлэх зорилго чиглэл алдагдах эрсдэл үүссэн байна. Мөн аймгийн ЗДТГ-аас ЖГҮ- ний үр дүнд, дүн шинжилгээ хийж хангалтгүй үнэлэгдсэн сумдад хариуцлага тооцож, ажил сайжруулах арга хэмжээ авсан зүйл байхгүй байлаа.

Иймд зарим сумд ЖГҮ-гээр хангалтгүй үнэлэгдсэн нөхцөл шалтгааныг тодруулан, орон нутгийн хөгжилд сөргөөр нөлөөлж буй үр дагаврыг тодорхойлж, цаашид тус асуудлыг сумдын Засаг дарга нартай байгуулах хамтран ажиллах гэрээнд тусган, гүйцэтгэлийг үнэлж, ажилдаа хариуцлагагүй хандсан албан тушаалтнуудад хариуцлага тооцон бүх сумдыг урамшууллаа бүрэн авах шаардлага тавьж ажиллах хэрэгтэй байна.



Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, түүний үр дүнд төсвийн ерөнхийлөн захирагчаас хяналт-шинжилгээ, үнэлгээ огт хийгдээгүй байна

Олон улсын байгууллага, гадаад орны Засгийн газар, байгууллага, иргэдээс олгосон зээл, өгсөн хандив, тусламж, тэдгээртэй адилтгах хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад төсвийн ерөнхийлөн захирагчаас хяналт тавих ажлыг Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм” –д заасны дагуу орон нутагт Санхүүгийн хяналт аудитын алба гүйцэтгэхээр байна.

Мөн аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэс гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж холбогдох төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх талаар тухайн үед мөрдөгдөж байсан ЗГ-ын 2017 оны 89 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-аар тус тус зохицуулсан байна.

Гэвч аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба болон Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсээс олон улсын байгууллага, гадаад орны Засгийн газар, байгууллага, иргэдээс олгосон зээл, өгсөн хандив, тусламж, тэдгээртэй адилтгах хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад 2016-2020 онд хяналт шалгалт хийгээгүй байна.

Тайлбар: Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэс *“Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилт”* –ийн тайланг холбогдох хэлтсүүдээс ирүүлээгүй гэсэн шалтгаанаар хяналт шинжилгээ үнэлгээ хийгдээгүй гэсэн тайлбар ирүүлсэн.

Энэ нь ЗГ-ын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 5 дугаар зүйлийн 5.2.6¹⁰, тухай үед мөрдөгдөж байсан ЗГ-ын 2017 оны 89 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 7 дугаар зүйл 7.4¹¹ -т заасныг тус тус зөрчсөн байна.

Энэ нь Санхүүгийн хяналт, аудитын алба, Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсийн ажлын хариуцлагагүй байдал, аймгийн ЗДТГ-ын хэлтэс агентлагууд ажлын уялдаа холбоогүй ажиллаж илтгэж байна. Мөн олон улсын байгууллага, гадаад орны Засгийн газар, байгууллага, иргэдээс олгосон зээл, өгсөн хандив, тусламж, тэдгээртэй адилтгах хөрөнгийн ашиглалт, зарцуулалт хяналтгүй, үр ашиггүй зарцуулагдах эрсдэлийг

¹⁰ Засгийн газрын тусгай сан, төсвөөс олгосон санхүүгийн тусламж, дэмжлэг, эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглуулж байгаа төсвийн хөрөнгө, олон улсын байгууллага, гадаад орны Засгийн газар, байгууллага, иргэдээс олгосон зээл, өгсөн хандив, тусламж, тэдгээртэй адилтгах хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавих.

¹¹ Энэхүү журмын 3.2.2-т заасан бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний явцын болон эцсийн тайланг мөн журмын 2-5 дугаар хавсралтын дагуу гаргаж, журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлнэ.

бий болгосон байна.

Иймд гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийх, олон улсын байгууллага, иргэдээс олгосон зээл, өгсөн хандив, тусламж, тэдгээртэй адилтгах хөрөнгийн ашиглалт зарцуулалтад хяналт тавих ажлыг жил бүр хийж, холбогдох хууль, журмын хэрэгжилтийг хангаж, хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн иргэдийн амьдрал, нийгэмд үзүүлсэн үр нөлөөг тодорхойлж, төслийн хэрэгжилтийн дараах тогтвортой байдлыг хангаж ажиллах шаардлагатай байна.



Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

Бүлэг А. Гадаадын зээл тусламжаар ТАХ хэрэгжүүлэх талаар орон нутагт баримтлах нэгдсэн хөтөлбөр байхгүй, төлөвлөлт хангалтгүй байна

А.1 Дундговь аймаг гадаад харилцаанд баримтлах нэгдсэн хөтөлбөр, зохион байгуулалт байхгүйгээс Засгийн газрын болон бусад шугамаар хэрэгжиж буй ТАХ-г орон нутагт хэрэгжүүлэх боломжийг алдсан байна.

А.1.1 Дундговь аймагт гадаад харилцаанд баримтлах нэгдсэн хөтөлбөр, зохион байгуулалт байхгүй байна.

А.1.2 Засгийн газрын шугамаар хэрэгжсэн 9 төсөл арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлж, 62 төсөл арга хэмжээг орон нутагт хэрэгжүүлэх боломжийг алдсан байна

А.2 Гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр хийх ажлыг аймгийн урт болон дунд хугацаанд хэрэгжүүлэх бодлоготой уялдуулан, нарийвчлан төлөвлөж, хэрэгжүүлэх ажил хангалтгүй байсан байна.

А.2.1 Төсөл хэрэгжүүлэх нэгжүүд ТАХ-г хэрэгжүүлэх сумдыг төслийн зорилго, зорилтын дагуу сонгож, шаардлагатай ТАХ-г санхүүжүүлсэн боловч зарим сумдын идэвх оролцоо муу байна.

А.2.2 Дундговь аймаг 2018-2020 онд гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр хийх ажлыг аймгийн урт болон дунд хугацаанд хэрэгжүүлэх бодлогын баримт бичигт тусгасан боловч жилийн төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй байна.

Бүлэг Б. ТАХ-г гэрээ хэлэлцээрийн дагуу үр дүнтэй хэрэгжүүлсэн боловч төслийн хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг тооцож ажиллаагүй байна.

Б.1. Төслийн батлагдсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Б.1.1 Олон Улсын байгууллагаас хэрэгжүүлж буй төслийн худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.

Б.1.2 “Зах зээл ба бэлчээрийн удирдлага хөгжил” төслөөр нийлүүлсэн хөрөнгийн бүртгэл зөрүүтэй, түүний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.

Б.1.3 Олон улсын байгууллагын төслийн хөрөнгөөр худалдан авсан болон нийлүүлсэн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж байна.

Б.2 Төслийн хэрэгжилтэд төсвийн ерөнхийлөн захирагчаас хяналт тавих ажил хийгдээгүй байна.

Б.2.1 Төслийн жилийн үйл ажиллагааны тайлан, гэрээний хэрэгжилтийн үр дүнг жил бүр гарган, төслийн ажилтны гүйцэтгэлийг үнэлэн ажилласан байна.

Б.2.2 Олон улсын байгууллагаас хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг шилэн дансны цахим хуудаст бүрэн мэдээлээгүй байна

Б.2.3 Төсөл хэрэгжүүлэгч нэгжүүдийн хяналтаар илэрсэн зөрчилд дүгнэлт хийж зөрчлийг арилгах, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажил хангалтгүй байна.

Б.2.4 Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, түүний үр дүнд төсвийн ерөнхийлөн захирагчаас хяналт-шинжилгээ, үнэлгээ огт хийгдээгүй байна.



Зөвлөмж

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд

1. Аймгийн Засаг даргаас гадаад харилцаа хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх нэгдсэн хөтөлбөрийг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

Аймгийн Засаг даргад

1. Монгол Улсад Засгийн газрын болон бусад шугамаар хэрэгжиж байгаа гадаадын зээл, тусламжийн мэдээллийн нэгдсэн баазыг бий болгон, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлэх боломжгүй ТАХ-г гадаад эх үүсвэрээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн бодлогоор хангах хөтөлбөр боловсруулан хэрэгжилтийг нь хангаж ажиллах;
2. Гадаад орнуудтай тогтоосон хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр хийх ажлыг аймгийн урт болон дунд хугацаанд хэрэгжүүлэх бодлоготой уялдуулан, нарийвчлан төлөвлөж хэрэгжүүлэх;
3. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан ажилтныг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжоор хангаж ажиллах;
4. Сумдын Засаг дарга нартай байгуулах хамтран ажиллах гэрээнд ОНХС-ийн урамшууллыг бүрэн авах шаардлагыг тусган, гүйцэтгэлийг үнэлж, үр дүнг тооцож ажиллах;

Аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэст

1. Дундговь аймагт гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ үнэлгээ хийж хууль, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах;

Санхүүгийн хяналт, аудитын алба

1. Олон улсын байгууллага, иргэдээс олгосон зээл, өгсөн хандив, тусламж, тэдгээртэй адилтгах хөрөнгийн ашиглалт зарцуулалтад хяналт тавих ажлыг жил бүр хийж, холбогдох хууль, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах.

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР

Д.ИХБАЯР

АУДИТОР

Д.ДОЛЖИНСҮРЭН

ХЯНАСАН :

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.НАРАНЦАЦРАЛ

Шалгагдагч байгууллагаас ирсэн санал

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасны дагуу аудитын тайлангийн төслийг аймгийн Засаг даргад танилцуулж санал тайлбарыг авлаа.


**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**
40080 Дундговь аймаг, Сайныгалан сум
Утас/Факс: 70592494
Цахим хаяг: info@dundgov.gov.mn

Б. Мөнхсайхан
Аудитын төлөөлөгч
орлогын, төлөвлөлийн
бодлогын тухай
2021-04-05 № 8/1064

танилцуулсан № _____

**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Төрийн аудитын газраас аймгийн 2018-2020 онд олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлсэн төлөвлөлт, хэрэгжилт, үр нөлөөнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа.

Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-г ирүүлсэн тайлангийн дүгнэлт, зөвлөмжийн дагуу дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

1.Аймгийн “Гадаад харилцаанд баримтлах бодлого”-ын баримт бичгийг боловсруулж батлуулах

2.Монгол Улсад Засгийн газрын болон бусад шугамаар хэрэгжиж байгаа гадаадын эзэл, тусламжийн мэдээллийн нэгдсэн баазыг бий болгож, нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах

3.Гадаад орнуудтай тогтоосон хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээнүүдийг жил бүрээр төлөвлөн хэрэгжүүлж ажиллах

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА *М. Цогзориг* ЦОГЗОЛМАА

Тайлан баталгаажуулсан тушаал



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2021 оны 04 сарын 09 өдөр

дүгээр 01/11

Мэдээлэл

Гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.1, 1.3, 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Олон улсын байгууллагаас орон нутагт хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилт, үр нөлөө”-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг / ДУА-2021/81-ШТА-ГА /-г баталсугай.
2. Аудитаар илэрсэн зөрчлийн ажлаалт (албан шаардлага, зовломж) –ийг хавсралтаар баталсугай.
3. “Олон улсын байгууллагаас орон нутагт хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилт, үр нөлөө”-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.
4. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгуулах, албан шаардлага, зовломжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг аймаг, сумын хэмжээнд зохион байгуулж, хэрэгжилтийг бүрэн хангуулах, үр дүнгийн талаар 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга С.Од-Орцон, аймгийн Засаг дарга /Д.Монхбат/ нарт зөвлөсүгэй.
5. Аудитаар өгсөн зовломж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тусгон 2021 оны 4 дүгээр улиралд танилцуулахыг ахлах аудитор /Д.Ихбаар/-т үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭНЭГЧ Р.МОНХТОГТОХ



0012010057

Дундговь аймаг дахь Төрийн
аудитын газрын дарга, тэргүүлэх
аудиторын 2021 оны 7 дугаар
сарын 09 – ны өдрийн А/17 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

Аудитаар илрүүлсэн зөрчлийн жагсаалт

Аудитын нэр : “Олон улсын байгууллагаас орон нутагт хэрэгжүүлж байгаа төсөл,
хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилт, үр нөлөө”

Аудитын код : ДУА-2021/81-ШТА-ГА

/сая төгрөгөөр/

№	Аудитаар илэрсэн асуудал /Зөрчлийн товч утга /	Зөрчлийн дүн /мянган. төгрөг/	Үүнээс			
			Аудитын явцад барагдуулсан	Акт тавигдсан	Албан шаардлага өгсөн	Зөвлөмжөөр өгсөн
1	Аймгийн Засаг даргаас хэрэгжүүлж буй гадаад харилцаа хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй нэгдсэн хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй. /Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал/					+
2	Сумдын Засаг нартай байгуулсан жилийн хамтран ажиллах гэрээнд ОНХС-ийн урамшууллыг бүрэн авах шаардлагыг тусгаагүй, гүйцэтгэлийг үнэлж, үр дүнг тооцож ажиллаагүй байна. /Аймгийн засаг дарга/					+
3	Аймгийн ЗДТГ нь аймгийн гадаад харилцааны нэгдсэн хөтөлбөрийн төлөвлөлт хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллаагүй. /Аймгийн засаг дарга/					+
4	Гадаад орнуудтай тогтоосон хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр хийх ажлыг аймгийн урт болон дунд хугацаанд хэрэгжүүлэх бодлоготой уялдуулан, нарийвчлан төлөвлөөгүй; /Аймгийн засаг дарга/					+
5	Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан ажилтан тогтвор суурьшилтай ажиллуулаагүй; Аймгийн засаг дарга/					+
6	Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй. /Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэс/					+

7	Олон улсын байгууллага, иргэдээс олгосон зээл, өгсөн хандив, тусламж, тэдгээртэй адилтгах хөрөнгийн ашиглалт зарцуулалтад хяналт тавих ажлыг жил бүр хийж, холбогдох хууль, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах. /Санхүүгийн хяналт, аудитын алба/					+
8	Эрдэнэдалай суманд “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслөөр хэрэгжүүлсэн “Малын эрсдэлийн сан” бүрдүүлэх /Өвс,тэжээл бэлтгэх/ ажлын худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, шууд худалдан авалт хийсэн. /Эрдэнэдалай, Сайхан-Овоо сум /	40.0			40.0	
9	“Малын эрсдэлийн сан” бүрдүүлэх чиглэлээр худалдан авсан өвс, тэжээлийн бүртгэл тооцоог хийгээгүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй. /Эрдэнэдалай, Сайхан-Овоо сум /					
10	Зах зээл ба бэлчээрийн удирдлага хөгжил төслөөр 2019 онд хэрэгжсэн 58,139.9 мянган төгрөгийн өртөгтэй 3 гүний худгийг бүртгээгүй, 22,894.0 мянган төгрөгийн өртөгтэй 3 ванныг 1.1 сая төгрөгөөр илүү бүртгэсэн. /Сайхан-Овоо/	59.2			59.2	
11	Төслийн хөрөнгөөр 2019 онд хийгдсэн 2 мал угаалгын ванныг 1,262.7 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн, 19,380.0 мянган төгрөгийн өртөгтэй 1 худаг, “Малчдын мэдээллийн төвийн тохижуулалт” төслийн хүрээнд нийлүүлэгдсэн 5,000.0 мянган төгрөгийн өртөгтэй ширээ, сандал, бусад тоног төхөөрөмжийг бүртгэл тайланд тусгаагүй. /Эрдэнэдалай сум /	25.6			25.6	
12	Зах зээл ба бэлчээрийн удирдлага хөгжил төслөөр 2020 онд хэрэгжсэн 1 ванныг 4,136.4 мянган төгрөгөөр, 2 гүний худгийг 13,432.6 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн. /Адаацаг сум/	17.6			17.6	
13	Зах зээл ба бэлчээрийн удирдлага хөгжил төслөөр 2020 онд хэрэгжсэн 2 ванныг 1,499.4 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн. /Говь-Угтаал сум/	1.5	1.5			
14	“Зах зээл ба бэлчээрийн удирдлага хөгжил төсөл”-ийн хүрээнд 2020 онд хэрэгжсэн 2 мал угаалгын ванныг 12,600,000 төгрөгөөр, 1 гүн өрмийн худгийг 5,000,000 төгрөгөөр нийт 17,600,000 төгрөгөөр дутуу бүртгэсэн. /Дэрэн сум/	17.6			17.6	
15	Зах зээл ба бэлчээрийн удирдлага хөгжил төслөөр 2019 онд “Малчдын мэдээллийн төвийн тохижуулалт” төслөөр хэрэгжсэн 5,000.0 мянган төгрөгийн өртөгтэй ширээ, сандал, бусад тоног төхөөрөмжийг бүртгэл тусгаагүй, мөн 19,380.0 мянган төгрөгийн өртөгтэй гүний худгийг бүртгээгүй. /Дэлгэрцогт сум/	24.4			24.4	

16	“Жижиг дунд бизнес эрхлэгчдийн ажлын байрны засвар” төслийн хүрээнд Дэлхийн зөн ОУБ-аас хандиваар өгсөн барилгыг 2019 онд 50,000.0 мянган төгрөгөөр засварласан боловч тухайн барилгыг орон нутгийн өмчид бүртгэж аваагүй, ашиглалт хангалтгүй. / Аймгийн Орон нутгийн өмчийн газар /	50.0			50.0	
17	2020 онд төслөөр хийгдсэн 13,788.1 мянган төгрөгийн 1 ванныг Сайнцагаан сум бүртгэл, тайланд бүртгээгүй. / Сайнцагаан сум /	13.8			13.8	
18	2020 онд төслөөр хийгдсэн мал угаалгын 15 ванны ус сорох помп, Сайхан-Овоо суманд хийгдсэн мал угаалгын ванны мал хаших 19 хашааг гүйцэтгэгч байгууллагуудаас гаргуулан авч холбогдох сумдад хүлээлгэн өгөөгүй. Төслөөр хийгдсэн мал угаалгын ванныг сумдын хувийн мал эмнэлгүүдэд, гүний худгийг нутгийн иргэдэд хариуцуулан үлдээхдээ, хөрөнгө хүлээлцсэн акт үйлдэж, баталгаажуулж хүлээлгэн өгөөгүй, эд хариуцагчийн гэрээг хийгээгүй. / Аймгийн Мал эмнэлийн газар /	-				
19	“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн хөрөнгөөр бичил бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор хуучин ЗДТГ-ын барилгыг 44,500.0 мянган төгрөгөөр засварласан боловч дээрх зориулалтаар нь ашиглаагүй. / Дэлгэрцогт сум /	44.5			44.5	
20	“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн хөрөнгөөр бичил бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор Эм эргэлтийн сангийн барилгыг 35,000.0 мянган төгрөгөөр засварласан боловч дээрх зориулалтаар нь ашиглаагүй. / Эрдэнэдалай сум /	35.0			35.0	
Дүн		329.2	1.5	-	327.7	-

Хавсралт 1

ДУНДГОВЬ АЙМГИЙН БОЛОВСРОЛЫН САЛБАРТ ОЛОН УЛСЫН
БАЙГУУЛЛАГААС 2018-2020 ОНД ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР /сая.төг/

№	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага	Төслийн нэр	Бүртгэлтэй байгууллага	Хэрэгжсэн он	Нийт дүн
1	Дэлхийн банк	Бидний дуртай математик	Хүмүүнлэг сургууль	2018	1.2
2	Дэлхийн банк	Хичээлийн судалгаа хамтын хөгжил	Хүмүүнлэг сургууль	2019-2020	13.2
3	Дэлхийн банк	Гэрэлт ирээдүй / 6 настай хүүхдийн хоцрогдол олгох/	Эрдмийн далай цогцолбор	2019-2020	13.0
4	Дэлхийн банк	Туршиж үзээд тунгаан бодъё	Говийн ирээдүй	2019-2020	13.7
5	Дэлхийн банк	Эко багачууд	Өндөршил сургууль	2019-2020	13.7
6	Дэлхийн банк	Миний дотуур байр – Миний хөгжих орчин төсөл	Луус Сургууль	2019-2020	25.0
7	ДЗОУБ, Мобиком корпорац, Орон нутгийн хөгжлийн сан	Ариун цэврийн байгууламж	Луус Сургууль	2018	80.0
8	БНСУ Keimyung соёлын их сургууль	Сургуулийн дээд доод давхрын шал солих	Луус Сургууль	2018	12.0
9	Азийн хөгжлийн банк	Оюуны хөгжил	Хулд Сургууль	2019-2020	13.2
10	Азийн хөгжлийн банк	Бага ангийн номын сан	Гурвансайхан Сургууль	2019	5.2
11	Японы Өвсний үндэс хөтөлбөр	Сургуулийн халаалтын системийн засвар	Адаацаг Сургууль	2018	125.8
12	Арабын Нэгдсэн Эмират улсын элчин сайдын яамны тусламж	Сургууль дотуур байрны засвар	Дэрэн сургууль	2019	276.4
	Нийт дүн				592.3

Хавсралт 2

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ ОЛОН
УЛСЫН БАЙГУУЛЛАГААС 2018-2020 ОНД ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР /сая.төг/

№	Санхүүжүүлэгч байгууллага	Төслийн нэр	Төсөл хэрэгжсэн газар	Хэрэгжсэн он	Нийт үнэ
1	Францын аксион монгол нийгэмлэгийн хамтын ажиллагаа	"Хэвлийн хөндийн болон эмэгтэйчүүдийн дурангийн мэс заслыг хөгжүүлэх" төсөл	Нэгдсэн эмнэлэг	2018	447.8
2	Шведийн smorr-н нярайн түнхний дисплазийн хэт авианы шинжилгээ.мултралаас сэргийлэх эмчилгээ төсөл	Нярайн түнхний үеийн дисплазийн эрт илрүүлэлтийг эрчимжүүлэх,мултралаас сэргийлэх	Нэгдсэн эмнэлэг	2015-2018	42.1
3	Люксембургийн их гүнт улсын буцалтгүй тусламж Зүрхний төв mon-006 төсөл	Зүрх судасны өвчний эрт илрүүлэг оношилгоо.эмчилгээг сайжруулах	Нэгдсэн эмнэлэг	2018	6.9
4	ЭМСХХ-6	ЭМСХХ 6 төсөл	Нэгдсэн эмнэлэг	2016-2018	481.6
5	Францын аксион монгол нийгэмлэгийн хамтын ажиллагаа	Яаралтай түргэн тусламжийн тоног төхөөрөмж	Нэгдсэн эмнэлэг	2014-2018	34.3

6	Япон улсын зг төсөл	Эхо аппарат/4d/	Нэгдсэн эмнэлэг	2019	206.0
7	Эх нярайн зайн оношилгооны төсөл	Нярайн сипап	Нэгдсэн эмнэлэг	2019	24.9
8	НҮ-ны байгууллага	Өсвөр үе ээлтэй орчин	Нэгдсэн эмнэлэг	2020	12.0
9	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага	Рентген аппарат/зөөврийн/	Нэгдсэн эмнэлэг	2020	199.4
10	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага	Биохимийн иж бүрдэл	Гурвансай хан ЭМТ	2020	49.0
11	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага	“Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад мобайл технологийг нэвтрүүлэх” төсөл	Адаацаг ЭМТ	2019	25.0
12	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага	Ковидын сургалт	ЭМГ	2020	9.0
13	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага	Тоног төхөөрөмж	ЭМГ	2019	3.9
14	Глобал сангийн төслөөр	Сүрьеэгийн сургалт	ЭМГ	2020	20.8
Нийт					1,562.7

Хавсралт 3

ДУНДГОВЬ АЙМГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРТ ОЛОН
УЛСЫН БАЙГУУЛЛАГААС 2018-2020 ОНД ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР /сая.төг/

№	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага	Төслийн нэр	Бүртгэлтэй байгууллага	Хэрэгжсэн он	Нийт дүн
1	Азийн хөгжлийн банк	Гүний худаг	Сумдын ЗДТГ	2020	52.0
2	НҮБ-ийн ХААХОУС	Зах зээл ба бэлчээрийн удирдлага төсөл	Сумдын ЗДТГ	2018-2021	1,340.0
3	Швейцарын хөгжлийн агентлагийн	"Ногоон алт, Малын эрүүл мэнд" төсөл	Сумдын ЗДТГ	2017-2020	77.6
Нийт дүн					1,469.6

Хавсралт 4

ДУНДГОВЬ АЙМАГТ ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГААС 2018-2020 ОНД
ДЭД БҮТЭЦИЙН САЛБАРТ ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР /сая.төг/

№	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага	Төслийн нэр	Төсөл хэрэгжсэн газар	Бүртгэлд авсан он	Нийт дүн
3	Азийн хөгжлийн банк	3000м3 хүчин чадалтай биологи цэвэрлэгээтэй цэвэрлэх байгууламж	Хот тохижуулах газар	2020-2021	8,395.5
4	Дэлхийн банк	Аймгийн төвийн 0,4кВ-ын хуваарилах сүлжээг 100% шинэчлэх, хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний тоолуурыг ухаалаг тоолуураар солих ажил	Цахилгаан түгээх станц	2020-2021	4,600.0
Нийт дүн					12,995.5

Хавсралт 4

ДУНДГОВЬ АЙМАГТ ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГААС 2018-2020 ОНД
БУСАД САЛБАРТ ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР /сая.төг/

№	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага	Төслийн нэр	Төсөл хэрэгжсэн газар	Бүртгэлд авсан он	Нийт дүн
1	Азийн хөгжлийн банк	ХНХЯам болон ХХҮЕГазраас хэрэгжүүлсэн төсөл	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар	2020	23.8
2	Дэлхийн банк	ХНХЯам болон ХХҮЕГазраас хэрэгжүүлсэн төсөл	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар	2020	36.8
3	Канадын Мерит төсөл ТЗУХ, ХОХБТХ	Боловсон хүчний чадавхжуулалт	Бүх төсвийн байгууллага	2019-2020	82.0
4	Тогтвортой амьжиргаа 3 төсөл	ОНХС-д урамшуулал, дэмжлэг олгох	15 сум	2018-2021	1,704.5
	Нийт дүн				1,847.1

Хавсралт 5

ЗАХ ЗЭЭЛ БА БЭЛЧЭЭРИЙН УДИРДЛАГЫН ТӨСЛӨӨР ХЭРЭГЖСЭН ТӨСЛИЙН БҮРТГЭЛ
ТАЙЛАНД МЭДЭЭЛЭГДСЭН БАЙДАЛ /2018-2020 ОНД ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР
/сая.төг/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Бүртгэлд тусгах дүн			Бүртгэлд тусгасан дүн			Зөрүү
		Тоо	Үнэ	Нийт	Тоо	Үнэ	Нийт	
1	Сайхан-овоо Ванн	3	7.6	22.9	3	8.0	24.0	(1.1)
2	Сайхан-овоо Худаг	3	19.4	58.1	3	-	-	58.1
3	Сайхан-овоо ажлын байрны засвар	1	40.0	40.0	1	40.0	40.0	-
4	Эрдэнэдалай Ванн	2	7.6	15.3	2	7.0	14.0	1.3
5	Эрдэнэдалай Худаг	1	19.4	19.4		-	-	19.4
6	Эрдэнэдалай ажлын байрны засвар	1	35.0	35.0	1	35.0	35.0	-
7	Дэлгэрцогт Ванн	2	7.6	15.3	2	7.6	15.3	0.003
8	Дэлгэрцогт Худаг	1	19.4	19.4		-	-	19.4
9	Сайнцагаан ажлын байрны засвар	1	50.0	50.0		-	-	50.0
10	Дэлгэрцогт бусад	1	5.0	5.0		-	-	5.0
11	Дэлгэрцогт үлхий цөслөгч	10	0.5	5.3	10	0.5	5.3	-
12	Дэлгэрцогт оготно устгал	10	0.2	2.4	10	0.2	2.4	-
13	Дэлгэрцогт өвс тэжээл	1	20.0	20.0	1	20.0	20.0	-
14	Сайхан-Овоо бусад	1	5.0	5.0		0.0	5.0	-
15	Сайхан-Овоо үлий цөмлөгч	10	0.5	5.3	10	0.5	5.3	-
16	Сайхан-Овоо оготно утагч	10	0.2	2.4	10	0.2	2.4	-
17	Сайхан-Овоо өвс тэжээл	1	20.0	20.0	1	20.0	20.0	-
18	Эрдэнэдалай бусад	1	5.0	5.0		-	-	5.0
19	Эрдэнэдалай үлий цөмлөгч	10	0.5	5.3	10	0.5	5.3	-
20	Эрдэнэдалай оготно утагч	10	0.2	2.4	10	0.2	2.4	-
21	Эрдэнэдалай өвс тэжээл	1	20.0	20.0	1	20.0	20.0	-
22	Адаацаг Ванн 2020	1	13.8	13.8	1	9.7	9.7	4.1
23	Адаацаг Худаг 2020	2	22.4	44.8	2	15.7	31.3	13.4
24	Баянжаргалан Ванн 2020	1	14.3	14.3	1	14.3	14.3	-
25	Говь-Угтаал Ванн 2020	2	14.3	28.5	2	15.0	30.0	(1.5)
26	Гурвансайхан Ванн 2020	1	14.8	14.8	1	14.8	14.8	-
27	Дэрэн Ванн 2020	2	14.8	29.6	2	8.5	17.0	12.6

28	Дэрэн худаг 2020	1	20.1	20.1	1	15.1	15.1	5.0
29	Луус худаг 2020	2	20.2	40.3	2	20.2	40.3	-
30	Өлзийт худаг 2020	3	20.1	60.2	3	20.1	60.2	-
31	Сайнцагаан Ванн 2020	2	14.8	29.6	2	14.8	29.6	-
32	Сайнцагаан Ванн 2020	1	13.8	13.8	1	-	-	13.8
33	Сайхан-Овоо худаг 2020	2	22.4	44.8	2	22.4	44.8	-
34	Сайхан-овоо ванн 2020	1	13.8	13.8	1	13.8	13.8	-
35	Хулд худаг 2020	3	19.9	59.7	3	19.9	59.7	-
36	Эрдэнэдалай худаг 2020	5	22.4	111.9	5	22.4	111.9	-
37	Эрдэнэдалай Ванн 2020	2	13.8	27.6	2	13.8	27.6	-
38	Цагаандэлгэр Ванн 2020	2	14.3	28.5	2	14.3	28.5	-
39	Баянжаргалан саравч 2020	1	104.6	104.6	1	104.6	104.6	-
40	Дэлгэрцогт саравч 2020	1	71.5	71.5	1	71.5	71.5	-
41	Эрдэнэдалай саравч 2020	1	99.9	99.9	1	99.9	99.9	-
42	Дэлгэрцогт ажлын засвар 2020	1	44.5	44.5	1	44.5	44.5	-
43	Мал үржлийн тоног 2020	1	35.9	35.9	1	35.9	36	-
44	Дэлгэрцогт энгийн уурхай худаг	7	0.5	3.5	1	3.5	4	-
45	Эрдэнэдалай энгийн уурхай худаг	13	0.5	6.5	1	6.5	7	-
46	Сайхан-овоо энгийн уурхай худаг	8	0.5	4.0	1	4.0	4	-
НИЙТ ДҮН		147		1,340.0	116	784.9	1,135.5	204.5

*Зөрүүний цэнхэр өнгөөр будсан тоо бүртгээгүй, улаан өнгөөр будсан нь зөрүүтэй бүртгэлийг харуулсан

Хавсралт 6

ДУНДГОВЬ АЙМАГТ ЗАСГИЙН ГАЗРЫН ШУГАМААР ГАДААДЫН ЗЭЭЛ БОЛОН ТУСЛАМЖААР 2016-2020 ОНД ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР /сая.төг/

№	Санхүүжүүлэгч байгууллага	Төслийн нэр	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага	Төсөл эхэлсэн огноо	Төсөл дуусах огноо	Гэрээний нийт дүн
1	Япон улсын “Өвсний үндэс-Хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламжийн хөтөлбөр”	Адаацаг сумын сургууль болон дотуур байрны уурын зуухны нэгдсэн гадна дулааны шугам сүлжээний ажил	БШУЯ	2017	2018	128.2
2	Япон улсын “Өвсний үндэс-Хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламжийн хөтөлбөр”	Сайнцагаан сумын 5-р цэцэрлэгийн их засварын ажил	БШУЯ	2016	2017	146.0
3	БНХАУ-ын Эксим банк /хөнгөлөлттэй зээл/	Улаанбаатар-Мандал-говийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцууд барих, ажлын зураг төсөл боловсруулах, тоног төхөөрөмж нийлүүлэх, барилга угсралт	ЭХЯ	2018	2019	327,400.0
4	Бүгд найрамдах Солонгос улсын “Экспорт импорт” банк /хөнгөлөлттэй зээл/	Дулааны станц 20МВт хүчин чадалтай	ЭХЯ	2017	2021	25,700.0
5	Азийн хөгжлийн банк	3000м3 хүчин чадалтай биологи цэвэрлэгээтэй цэвэрлэх байгууламж		2020	2021	8,395.5
6	Дэлхийн банкны хөрөнгө	аймгийн төвийн 0,4кВ-ын хуваарилах сүлжээг 100% шинэчлэх, хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний тоолуурыг ухаалаг тоолуураар солих ажил	ЭХЯ	2020	2021	4,600.0

7	НҮБ-ийн ХААХОУС	"IFAD" Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл	ХААХҮЯ	2018	2022	1,200.0
8	Дэлхийн банкны хөрөнгө	Тогтвортой амьжиргаа-3 төсөл	СЯ	2018	2022	1,704.5
9	Азийн хөгжлийн банк	Эрүүл мэндийн салбарын хөгжил төсөл V	ЭМЯ	2017	2018	486.5
	Нийт дүн					369,760.7

ТОГТВОРТОЙ АМЬЖИРГАА ТӨСЛӨӨС СУМДЫН ОНХС-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН БА ОЛГОСОН УРАМШУУЛЛЫН СУДАЛГАА

№	Сумдын нэр	2016 оны үнэлгээ			2017 оны үнэлгээ			2018 оны үнэлгээ			2019 оны үнэлгээ			2020 оны үнэлгээ			Нийт олгосон урамшуулал
		ЖГҮ оноо	Эрэмбэ	Урам-шуулал	ЖГҮ оноо	Эрэмбэ	Урам-шуулал	ЖГҮ оноо	Эрэмбэ	Урам-шуулал	ЖГҮ оноо	Эрэмбэ	Урам-шуулал	ЖГҮ оноо	Эрэмбэ	Урам-шуулал	
1	Дэлгэрцогт	22%	253		45%	94	3.1037	48%	184	6.2884	52%	235	7.432	65%	137	9.8461	26.67
2	Дэрэн	42%	61	34.3514	42%	109	3.9356	57%	111	9.3319	64%	149	10.6772	78%	41	14.1454	72.44
3	Говь-Угтаал	33%	143	31.5105	32%	214		55%	126	8.1847	53%	230	9.3179	45%	279		49.01
4	Цагаандэлгэр	38	93	28.7803	32	213		50	161	7.5411	41%	284		44%	289		36.32
5	Баянжаргалан	47%	33	30.5787	68%	7	3.727	61%	87	8.1947	59%	185	9.3056	66%	122	12.3282	64.13
6	Өндөршил	36%	108	34.4496	64%	13	4.8586	60%	93	11.5806	64%	144	13.108	53%	230		64.00
7	Гурвансайхан	29%	192		33%	207		45%	208	11.182	47%	261		61%	178	17.0805	28.26
8	Өлзийт	17%	294		36%	174	8.7096	26%	308		54%	223	24.5325	61%	177	32.501	65.74
9	Хулд	42%	63	39.8041	52%	49	5.4863	41%	239		78%	47	15.0811	72%	77	19.9798	80.35
10	Луус	46%	40	32.7917	44%	95	3.892	49%	179	7.642	61%	172	8.734	74%	63	11.5709	64.63
11	Дэлгэрхангай	37%	97	38.5878	42%	111	5.6519	40%	250		63%	158	16.9541	64%	138	22.4612	83.66
12	Сайхан-Овоо	48%	30	39.4347	50%	60	5.412	48%	188	16.0034	70%	100	18.1298	65%	127	24.0187	103.00
13	Эрдэнэдалай	49%	28	54.5756	53%	46	8.1675	50%	158	28.8483	69%	112	32.8693	68%	99	43.546	168.01
14	Адаацаг	47%	34	34.2293	59%	26	4.4683	68%	48	13.5747	77%	49	15.7081	78%	37	20.8104	88.79
15	Сайнцагаан	28%	208		41%	124	12.899	54%	128	29.7375	69%	104	35.1871	63%	154	46.6166	124.44
	Сумдын дундаж үнэлгээ болон нийт дүн	37%		399.1	46%	1,542.0	70.3	50%		158.1	9.2		217.0	9.6		274.9	1,119.5

*Шар болон цэнхэр хүрэн өнгөөр будсан нь тухай онд хангалтгүй үнэлгээ авч урамшуулалд хамрагдаагүй сумдыг харуулсан

